

Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газар

2024 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. Нэг: “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд:							
1	1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ	1.1.1. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана.	2021 - 2024			Кодид-19 -ын тандалт судалгаа, яаралтай бэлэн байдлыг халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг цаг тутам хангаж ажиллаж байна	100%
2		1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон	2021 - 2024			Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед Эрүүл мэндийн төв нь шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх	100%

		үед эрүүл мэндийн салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ.			бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлж 3 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.	
3		1.1.3. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл,	2021 - 2024		коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг, иргэдэд өгч сэрэмжлүүлэг мэдээлэлээр хангасан.цахим орчинд зурагт хуудас ведио шторк бэлтгэн мэдээлэл зөвлөгөө хүргэж байна.	90%

		зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээлэлээр хангах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна.					
4		1.1.4. “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Ковид-19 -ын тандалт судалгаа, яаралтай бэлэн байдлыг халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг цаг тутам хангаж ажиллаж байна	100%
5		1.1.5. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тусгаарлах болон	2021 - 2024			Эмч эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна. Хавсралт : 3 зураг	90%

		эмчлэн тусгаарлах байруудын бэлэн байдлыг шуурхай хангаж эмч эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллана				
2. ХОЁР. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд						
6	2.1. Эрүүл иргэн -Ирээдүйн үнэт зүйл	2.1.1. Төсөвт албан байгууллагуудыг ажлын байран дээрээ артерийн даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан тоног	2021 - 2024			төсөв, хөрөнгөтэй холбоотой хүлээгдэж байна. 0%

		төхөөрөмжийг бий болгон ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.					
7		2.1.2. Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг ханган, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.	2021 - 2024			одоогоор 20- иод нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийг улсын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр худалдан авалт хийгдэж бэлтгэл ажил бүрэн хангагдан ажиллаж байна. Мөн Эрдэнэмонгол ХХК - ны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн МонПэе төслийн 10 тооны тоног төхөөрөмжөөр хангах нөхцөл бүрдэн ажиллаж байна. Эрүүл мэндийн яамнаас бүрэн автомат анализотр Биохимийн аппарат, сүүлийн үеийн эхо аппарат ирэхээр байна.	100%
8		2.1.3. Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг зохион байгуулах замаар өвчлөлийг бууруулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ.	2021 - 2024			Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг улсын 2-р эмнэлгийн эмч нарын баг бүрэлдэхүүн тус суманд зохион байгуулж нийт 233 иргэнийг хамруулж ажилласан.Мөн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талын сургалт сурталчилгаа мэдээлэл зөвлөмжийг хүргэн ажиллаж байна. Хавсралт нийт : 5 Файл : 1 Зураг : 4	90%
9		2.1.4. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд	2021 - 2024			УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР ЭМЧ МЭРГЭЖИЛТЭНД БЭЛТГЭГДЭЖ ХАРААХАН АМЖААГҮЙ БАЙНА.	30%

		нийцсэн, хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлнэ.					
10		2.1.5. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, резидент сургалтад хамруулах, ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2024			2024 оны байдлаар эрүүл мэндийн төв нь нэг ажилтанаа ариутгагчаар сургаж, ур чадварын нэмэгдэл 4 ажилтан, товлогдсон эмчилгээ оношлогооны сургалтанд эмч сувилагч нараа тогтмол хамруулан ажиллаж байна.	100%
11		2.1.6. Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж эм эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт үнийн	2021 - 2024			2023 оноос хувийн эмийн сан нээгдэж эмнэлгийн болон иргэдийн эм эмнэлгийн эрэгслийн чанартай ханган нийлүүлэлт үнийн уян хатан байдлаар ажиллаж байна.ул	100%

		уян хатан бодлого хэрэгжүүлнэ.					
12		2.1.7. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ	2021 - 2024			Тус сумын нийт ард иргэдийн дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэх зорилгоор уралдаан тэмцээнүүдийг цаг тухай бүр Засаг даргын тамгын газрын ажилтан албан хаагчидтай хамтран зохион байгуулж ажилласан. Ерөнхий боловсролын сурагчдын дунд теннисны тэмцээн 2 насны ангилалаар зохион байгууллаа. Насны ангилал 3-5 анги, 6-9 ангийн дунд зохион байгуулж нийт 54 сурагч хамрагдлаа.2024 оны 1 дүгээр сарын 21-нд Малчид, төлчдийн зөвлөгөөнд зориулан явуулсан Бөхийн барилдаанд: Шинэжинст сумын залуу бөх Б. Энхмандах түрүүлж, Шинэжинст сумын залуу бөх М.Барс үзүүлж, Шөвгийн дөрөвт Шинэжинст сумын залуу бөх Б.Доржсамбуу , Баянговь сумын залуу бөх Б.Аззаяа нар тус тус шалгарч, уран барилдааны шагналыг Шинэжинст сумын залуу бөх А.Мөнхтогтох бөхчүүдийн барилдааныг Зараа багийн малчин А. Мөнхзолбоо, гэргий М.Алтанчимэг нар ивээн тэтгэж оролцсон.	100%
13	2.2. Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангах	2.2.1. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хооллолтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд чихэр тослогийг	2021 - 2024			Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хооллолтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд чихэр тослогийг бууруулах эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулах чиглэлийн сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж иргэдэд мэдээлэл зөвлөгөөг тасралтгүй хүргэж байна.Сургалтанд нийт 420 хүн хамрагдаж гарын авлага зурагт хуудсыг бэлтгэн тарааж өгсөн.	100%

		бууруулан эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулан үр дүнг тооцно.				
14		2.2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн хүлээгдэл чирэгдлийг бууруулна.	2021 - 2024		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг нэмэгдүүлэн ажиллахад дараах зарчмыг баримтлан ажиллаж байна. Аюулгүй байдал үйлчлүүлэгч болон эмч, эмнэлгийн ажилтнууд осол, алдаа, зөрчилд өртөхгүй байх, Цаг хугацаатай үйлчлүүлэгчид цаг хугацааны хоцрогдолгүй тусламж, үйлчилгээг хүргэх; Үр дүнтэй байдал үйлчлүүлэгчид хүргэсэн тусламж, үйлчилгээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байх, Үр ашигтай байдал төлөвлөсөн үр дүнд хамгийн боломжит бага зардлаар хүрсэн байх, Тэгш, хүртээмжтэй байдал ижил эмгэгтэй үйлчлүүлэгч бүр ижил тусламж, үйлчилгээ авах, боломжоор хангагдсан байх Үйлчлүүлэгч төвтэй байх тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн хэрэгцээнд үндэслэн, зохион байгуулж ажиллаж байна.	100%
15	2.3. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй	2.3.1. Багш, сурагчдын сурч хөгжих, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, багшийн мэргэжлийн болон багшлах ур чадварыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024		Эрхлэгч Багшийн хөгжлийг дэмжих мэргэжлийн сургалтад 2024 оны 01 сарын 08-16нд “Сургалтын арга зүй болон илтгэл бичих арга” сэдэвт сургалтад ажлын байрандаа цахимаар суралцаж 96% үзүүлэлттэй, Б.Цогзолмаа “Хүүхэд бүрийг бүтэн үгээр уншиж ярьж сурахад үзүүлэх дэмжлэг” сэдэвт сургалтад 100% үзүүлэлттэй, Э.Цэцэгжаргал багш “Блумын Таксономийн танин мэдэхүй үе шат” сэдэвт сургалтад 95% үзүүлэлттэй, М.Хишигбаяр багш “Сургалтын шинэлэг идэвхтэй аргуудыг сургалт үйл ажиллагаанд хэрэглэх нь” сэдэвт сургалтад 98% үзүүлэлттэй, Д.Одсүрэн	70%

	орчин бүрдүүлнэ.				багш “Сургалтын хэрэглэгдэхүүнийг олон хувилбараар хэрэглэх” сэдэвт сургалтад 98% үзүүлэлттэй 4 бүлгийн багш бүрэн хамрагдаж амжилттай төгсөөд байна. Бүлгийн хүүхдийн насны онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг улирал бүр сайжруулан боловсруулж, багш ажлын байрандаа хөгжих бололцоог ханган бүсийн хэмжээнд 2 удаа, аймгийн хэмжээнд 1 удаа сайжруулсан сургалтын хөтөлбөрийн хэлэлцүүлэг цахим сургалтад 4 бүлгийн багш нарыг бүрэн хамруулж, аймгийн 12,6,10 дугаар цэцэрлэгээр 5 багшийн хамт туршлага судлан ,туршлагаа солилцон биеийн тамирын талбай болон гадна талбайтай танилцаж өнгө үзэмжээ сайжруулж гадна табайг тохижуулан ажиллала	
16	2.3.2. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжинэ.	2021 - 2024			Сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэлийн 110.880.000 төгрөгийн тендер зарлагдан Зэт эн жи ххк шалгарсан боловч гэрээ байгуулах эрх олгогдоогүй байна.	50%
17	2.3.3. Сургууль, цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын	2021 - 2024			Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр урлагын заалны иж бүрэн засвар хийж хүүхдэд сурч хөгжихөд хэрэгцээтэй хөгжмийн зэмсэгүүдтэй болж хүүхэд хөгжих тайлан тоглолтоо хийх тайзтай болж, эцэг эх, багш ажилчдад сургалт явуулах бүрэн боломжтой ухаалаг дэлгэцтэй болон ханыг нь хүүхдэд ээлтэй дулаахан эсгий хавтангаар хийлгэж орчин нөхцөлийг	70%

	засвараар үе шаттай хангаж, удирдлагын чадавхийг сайжруулна.			сайжруулан сурч хөгжихөд тухтай таатай орчинг бүрдүүлээд байна.	
18	2.3.4. Боловсролын байгууллагуудын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ.	2021 - 2024		Сумын хэмжээний 2-5 настай нийт 243 хүүхдээс 125 хүүхдийг үндсэн бүлэгт хамруулан 3 -5 настай 30 хүүхдийг явуулын бүлэгт хамруулан нийт 155 хүүхдэд СӨБ-ын үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Сумын хэмжээний 5 настай 46 хүүхэд байгаагаас 35 хүүхэд үндсэн бүлэгт хамрагдан, явуулын бүлэгт 11 хүүхдийг бүртгэн авч сургалт үйл ажиллагааг хүргэн ажилласан. Явуулын бүлэгт бүртгэгдсэн 11 хүүхэд ээлжээр үндсэн бүлгийн сургалтад хамрагдан суралцаж СӨБ-ыг эзэмшин, тайлан тоглолтоо хийж сурсан мэдсэнээ эцэг эхдээ танилцуулан сургуульд элсэн суралцахад бэлэн болоод байна. 5 настай хүүхдийг 100% хамруулсан. ЕБС-ийн хамран сургалт 95 хувьтай.	90%
19	2.3.5. “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Эрхлэгч Багшийн хөгжлийг дэмжих мэргэжлийн сургалтад 2024 оны 01 сарын 08-16нд “Сургалтын арга зүй болон илтгэл бичих арга” сэдэвт сургалтад ажлын байрандаа цахимаар суралцаж 96% үзүүлэлттэй, Б.Цогзолмаа “Хүүхэд бүрийг бүтэн үгээр уншиж ярьж сурахад үзүүлэх дэмжлэг” сэдэвт сургалтад 100% үзүүлэлттэй, Э.Цэцэгжаргал багш “Блумын Таксономийн танин мэдэхүй үе шат” сэдэвт сургалтад 95% үзүүлэлттэй, М.Хишигбаяр багш “Сургалтын шинэлэг идэвхтэй аргуудыг сургалт үйл ажиллагаанд хэрэглэх нь” сэдэвт сургалтад 98% үзүүлэлттэй, Д.Одсүрэн багш “Сургалтын хэрэглэгдэхүүнийг олон хувилбараар хэрэглэх” сэдэвт сургалтад 98% үзүүлэлттэй 4 бүлгийн багш бүрэн хамрагдаж амжилттай төгсөөд байна.	90%
20	2.3.6. “Хүүхдийн амьдрах ухааны төв, хөдөлмөр	2021 - 2024		хэрэгжээд дууссан тул хасах хүслтэй байна.	100%

		зуслан“ –д сурагчдыг хамруулна.					
21		2.3.7. Сургуулийн өмнөх боловсрол, сургуульд “Авьяас” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Их Эзэн Богд Чингис хааны холбогдолтой “Өв соёл” үйл ажиллагаа зохион байгуулж, бүх багш ажилчид эрх тэгш оролцож, Эзэн Богд Чингис хааны “Монгол ёс уламжлалыг харуулсан үйлийг бэлтгэн урлагын танхимд нөлөөлийн үйл ажиллагаа зохион байгуулж морин хуурын дугуйлан хичээллүүлж нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. “Монгол бахархал”-ын сарын аяны хүрээнд бүлэг тус бүр хүүхдийн насны онцлогт таруулан Эзэн Чингис хаанаа магтсан дуу, шүлэг, ишлэл бүжиг зэргийг зааж сурган тайлангаа тавьж 7 хоног Монгол хувцсаараа гоёх, бахархах, ёс заншлаас суралцах, үйл ажиллагааг зохион байгуулж, үндэсний хувцас, монгол дээлний талаар зөв ойлголт хандлагыг өгч байгууллагын багш ажилчид хамтран ажиллаа.	70%
22		2.3.8. Орон нутаг дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр “Суралцаж байгаа оюутнуудыг боловсролын зээлийн сан“-д болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.	2021 - 2024			Сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Эрдэнэ монгол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд “Амралтаараа ажиллая” оюутан хөтөлбөр хэрэгжүүлж, 20 оюутан ЗДТГ-ын архивч, бичиг хэргийн эрхлэгч, оператор, газрын даамал, БОХУБ, Байгаль хамгаалагч гэх мэт чиглэлээр 1100000 төгрөгийн цалинтайгаар дадлагжин ажиллаж байна.	50%
23		2.3.9. “Монгол ухаан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021 - 2024			2020 онд хэрэгжээд дууссан тул хасах	100%

24		2.3.10. Сурагчдын оюуныг хөгжүүлэх, бие даан суралцах, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, уралдаан, тэмцээн, олимпиад зохион байгуулах. Санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024		Улсын төрөлжсөн олимпиадын 2ын даваанд нийт 10 багш, 8 сурагч амжилттай оролцож бага боловсролын багш нарын “Математик” төрөлд Э.Дүүрэнхундага дэд байр, “Дүрслэх урлаг” төрөл Э.Малийсүрэн багш Дэд байрыг тус тус эзэлсэн. 2 багшид 3 сарын ур чадварын нэмэгдэл 20 хувийг олгосон. Кенгуру олон математикийн уралдаанд нийт 34 суралцагч оролцож, 1 сурагч хүрэл медаль, I зэргийн диплом, 3 суралцагч III зэргийн диплом тус тус эзэлсэн. 4 суралцагчийн шагналыг 80.000 төгрөгөөр анги удирдсан багш нар ивээн тэтгэн шагнаж урамшуулсан. Сурагчдаа бэлтгэн оролцуулсан математикийн багш Ж.Пагмад 3 сарын ур чадварын нэмэгдэл 20 хувиар шагнаж урамшуулсан. Баянлиг сумд зохион байгуулагдсан АБТА алтан гадас одонт Д.Дашдаваагийн нэрэмжит аймгийн монгол хэлний олимпиадад нийт монгол хэл, бичгийн багш 2, дунд ангийн 8 сурагчтай оролцож, 9б ангийн ангийн сурагч Ж.Энхмэнд 9 дүгээр ангийн төрөлд Тэргүүн байр, багш М.Өлзийжаргалд 3 сарын ур чадварын нэмэгдэл 20 хувь, АБТА Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит бага ангийн монгол хэлний олимпиадад 2 багш,13 сурагч оролцож, 4б ангийн сурагч Б.Содномдорж тусгай байр, бэлтгэсэн багш Д.Ганболорт 1 сарын ур чадварын нэмэгдэл 20 хувиар тус тус шагнаж урамшуулсан.	100%
25		2.3.11. “Хос бичигтэн”, “Англи хэл”, “Робокон-Баянхонгор”,дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.	2021 - 2024		Энэ хичээлийн жилд Pearson-англи хэлний хичээлийг дэмжих цахим системийг нэвтрүүлэн хэрэглэж байна. Тус цахим системд 2 багш, 101 сурагчид хамрагдан амжилттай ажилласан. Хичээлийн байранд 16950000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 9 ширхэг access point болон бусад төхөөрөмжийг байршуулж, 100 хувь интернетийн орчин бүрдсэн. Мөн таблетны тоог 6-аар нэмэгдүүлж, нийт 21 таблет, сурагчийн ном, дасгал ажлын ном тус бүр 99 ширхэг ирж сургалтдаа ашиглаж байна. Хичээлийн цаг бүр дээр сургалтын хөтөлбөрийн дагуу сурагчиддаа дэмжлэг үзүүлэн ажиллахад 5 дугаар анги гарааны үнэлгээ 45 хувь, хичээлийн жилийн эцсийн үнэлгээ 60 хувь болж 15 хувиар, 6 дугаар	70%

					<p>анги гарааны үнэлгээ 40 хувь, жилийн эцсийн үнэлгээ 53 хувь болж 13 хувиар тус тус ахисан байна. монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 6-9-р ангийн сурагчдын үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг бүлэг сэдвээр үнэлэн ахиц амжилтыг харьцуулан дүгнэдэг. Амжилт 55% чанар 20% гүйцэтгэл 65 % байна. “Эх хэлээ өв тэгш суръя” 7-р ангийн сурагчдын дунд 3 үе шаттай зарлагдсан уралдаанд амжилттай оролцож, “Хөрвүүлэн бичих” төрөлд аймгийн хэмжээний 47 сургуулиас 90,5% гүйцэтгэлтэйгээр дэд байр эзэлж, нэг сурагч алдаагүй бичигтэн сурагчаар шалгарсан амжилттай. Баянлиг сумд болсон Дашдаваа багшийн нэрэмжит монгол хэл, бичгийн олимдиадад нийт 8 сурагч оролцож 9-р ангийн сурагч Ж.Энхмэнд тэргүүн байрт шалгарсан. Сурагчдын амралтын хугацаанд сургуулийн 42 багш ажилчдад компьютерт үндэсний бичгээр бичих 6 цагийн сургалт зохион байгуулж, багш нарын компьютерт үндэсний бичгээр бичих програм суулган өгснөөр цахим орчинд бичих чадвар эзэмшиж ахиц гарч байна. Сургалтын үр дүнд багш нар мэдээллийн самбар, ангийн булангаа үндэсний бичгээр бичиж, өөрийн эзэмшсэн чадвараа хэрэглээ болгож байгаа.</p>	
26	2.3.12. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлж	2021 - 2024		<p>Чадварлаг багш хөтөлбөрийг сайжруулан бага боловсролын багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах үүднээс орон нутгийн онцлогтой тэтгэмж олгох шалгуур үзүүлэлтийг сайжруулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулан батлуулсан. Тус хөтөлбөрийн үр дүнд бага боловсролын 8 багш, дунд боловсролын 5 багшид сумын Засаг даргын нөөц хөрөнгө оруулалтаар нийт 30 сая төргөрний урамшуулал олгосон.</p>	100%	

		шагнаж урамшуулна.					
27		2.3.13. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	2021 - 2024			2024 оноос дагаж мөрдөх хууль тогтоомж, боловсролын ерөнхий хуулиас НТБНБагш миний бие сургалтыг 32, татварын байцаагч сургууль дээр ирж 34 иргэнд сургалт зохион байгуулсан. Сумын байгаль орчон сургуулийн ЭКО кулбын багш сурагчтай хамтарч Удирдамж гаргаж ажлуудыг зохион байгуулж явуулсан. Үүнд 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Ус эрдэнэ” сэдвийн дор шүлгийн уралдаан зохион байгуулах, бичсэн шүлгээ зөв тодоор уншиж сургуулийн группт бичлэг хэлбэрээр байршуулна. Нийт 15 сурагч оролцсон. 6-9 ангийн сурагчдын дунд “Ус эрдэнэ” постор зургийн уралдаан тус тус зарлаж Шинэжинст сумын группт байршуулж иргэдэд усыг хайрлах талаар таниулсан. Мөн 1 дахь өдрийн мэдээллийн цагаар “Усаа хайран хамгаалах” талаар байгаль орчны улсын байцаагч хичээл орсон үүнд нийт 75 иргэн хамрагдсан. 2024 оны 03 дугаар сарын 28 “Хуримтлал” сэдэвтэй сургалтыг 6-9-р ангийн 170 сурагчдад ХААН БАНКНЫ эдийн засагч хичээл орсон. “Хамтарсан баг” “Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтарч дараах сургалтуудыг зохион байгуулсан. Удирдамжийн дагуу 6-9 ангийн охидуудад “Харилцаа ба хандлага” ЭМТ -өс “Сарын тэмдэг” эрүүл ахуй “Өсвөр үеийхнийн онцлог” сэдэвтэй сургалтуудыг нийт 62 охинд зохион байгуулсан. Мөн “Эр цэргийн ” баяраар эрчүүдэд “Дартс” “Хөгжөөнт Буухиа” ”Волейбол” тэмцээнүүдийг тус тус зохион байгуулсан нийт 60 иргэн хамрагдсан. Мөн сумын нийгмийн бодлогын ажилтан “Эрчүүд ба гэр бүл” сургалт зохион байгуулж явуулсан. “Шим тэжээлийн боловсрол” сэдэвт захиалгат сургалтыг 5 дэд сэдвийн хүрээнд 4 багштай хамтарч зохион байгуулсан. 1-5 ангийн 152 хүүхэд, 6-9 ангийн 120 сурагч, 80 иргэнд нийт 352 ирэн хамрагдсан байна. Мөн оёдолын сургалтыг өрхийн хөгжлийн 10 иргэнд тусгай багшаар эсгүүрийн хичээл орууллаа. Насан туршийн боловсролын 5 чиглэлээр 20 төрийн сургалт хичээлийг нийт 634 иргэн давхардсан тоогоор	70%

					боловсролын үйлчилгээ үзүүлсэн байна	
28	2.4. Иргэдийн нийгмийн баталгааг хангах	2.4.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана.	2021 - 2024		<p>2024 оны Зараа нэгдүгээр баг, Уртын гол хоёрдугаар баг, Эрдэнэшанд гуравдугаар баг, Эхнэхавцгай дөрөвдүгээр багуудын хурлаар явж давхардсан тоогоор 391 иргэнд мэдээлэл өглөө, хувиараа хөдөлмөр эрхлэгч ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдтэй уулзаж сайн дурын даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх тухай хуулийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, мөн тэдний гар утсанд “Нийгмийн даатгал” аппликейшнийг суулган өгч ашиглах зааврыг тайлбарлах, хэрэглээг нь нэмэгдүүлж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ болон ач холбогдлыг таниулж зөвлөгөө өгч мэдээлэл хийж, брошюр тараан ард иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч, мэдээлэл солилцлоо. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт Сайн дурын 287 даатгуулагчидтай гэрээ хийсэн. Үүнээс шинээр нийт 46 иргэнтэй сайн дурын гэрээ байгууллаа, Гэрээнд заасны дагуу төлөх шимтгэлийг тооцон авч 287 даатгуулагч хамруулж 2024 оны 06 дугаар сарын 19-ны байдлаар 195 945 730 төгрөгийн орлого оруулахаас 178 765 841 төгрөг хуримтлагдсанаар 91 хувиар биелүүлээд байна.</p> <p>Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд нийт 24 эхийг хамруулж жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд 10 784 510 төгрөгийн орлого оруулахаас 9 771 030 төгрөгийг хуримтлагдсанаар 90 хувиар биелүүлээд байна. Эхийн хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд нийт 20 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 9,115,880 төгрөгийн орлого оруулахаас 8,293,100 төгрөгийг хуримтлагдсанаар 90 хувиар биелүүлээд байна.</p> <p>Хавсралт : 7 зураг</p>	90%
29		2.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй	2021 - 2024	Тодорхойгүй	Суманд 25 ба түүнээс дээш ажилтантай байгууллага Ерөнхий боловсролын сургууль байдаг бөгөөд хөгжлийн	50%

	иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ.				бэрхшээлтэй 1 иргэнийг авч байнгын ажлын байранд ажиллуулж байна. Хөгжийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны иргэнд санхүүгийн дэмжлэг олгох зарыг цахимаар мэдээлж ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Отгонбатын санхүүгийн дэмжлэг хүссэн 8 сая төгрөгийн төслийг ХХҮГ-т хүргүүлж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, тусламжинд 7 иргэнд 1376000 төгрөгийн хөнгөлөлт олгож ажилласан.	
30	2.4.3. Ажилтай орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж 25-аас доошгүй иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдана.	2021 - 2024	0		Ажил хайгч иргэнээр 22 иргэнийг бүртгэсэн. -Ажлын байрны бүртгэлд 2 аж ахуйн нэгжийг бүртгэсэн -Ажлын байрны 25 захиалга бүртгэсэн.	70%
31	2.4.4. Ахмадын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж тухайн ахмад настангуудын өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	84 сая		-Ахмадын зөвлөх үйлчилгээний 2 төслийг хүлээн авч ХХҮГ-т хүргүүлсэн. -Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамруулахаар амхад настангуудад сургалт хийж 5 ахмадын төслийг ХХҮГ-т хүргүүлсэн.	70%
32	2.4.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2021 - 2024	84 сая		-Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэл хүргэж 1 иргэний төслийг ХХҮГ-т хүргүүлсэн. -Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээнд 9 өрхийн материалыг хүргүүлсэн. -Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээний зарыг цахим сайтад байршуулсан. -Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамруулахаар амхад настангуудад сургалт хийж 5 ахмадын	70%

					төслийг ХХҮГ-т хүргүүлсэн.	
33	2.4.6. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2021 - 2024	0		Суманд 25 ба түүнээс дээш ажилтантай байгууллага Ерөнхий боловсролын сургууль байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг авч байнгын ажлын байранд ажиллуулж байна. Хөгжийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны иргэнд санхүүгийн дэмжлэг олгох зарыг цахимаар мэдээлж ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Отгонбатын санхүүгийн дэмжлэг хүссэн 8 сая төгрөгийн төслийг ХХҮГ-т хүргүүлж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, тусламжинд 7 иргэнд 1376000 төгрөгийн хөнгөлөлт олгож ажилласан.	50%
34	2.4.7. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулна.	2021 - 2024	Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж Засаг даргын тамгын газрын Нийгмийн салбарын арга хэмжээний зардлаас 4 сая төгрөгийг зарцуулсан байна.		Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэр бүлийн боловсрол олгох, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, гэр бүлийн нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн сургалт, чуулган, спортын зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Хавсралт нийт : 9 Файл : 1 Зураг : 8	70%
35	2.4.8. Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлнэ.	2021 - 2024			Угийн бичиг хөтлөх аяны хэрэгжих хугацаа болоогүй. Хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд Одонгоо зүү арга эх үрсийн чуулганд "Угийн бичиг хөтлөх ач холбогдол" сэдвээр арга зүйн сургалтыг зохион байгуулж 160 гаруй эмэгтэйчүүд хамрагдсан. Мөн хүүхдүүдийн дунд "Ураг удмаа мэдье" ураг удмын багуудын гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 8 баг оролцсон.	70%

36		2.4.9. Угийн бичиг хөтлөх аян зохион байгуулна.	2021 - 2024	Засаг даргын тамгын газрын Нийгмийн салбарын зардлаас 200.000 төгрөг зарцуулсан байна.		Угийн бичиг хөтлөх аяны хэрэгжих хугацаа болоогүй. Хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд Одонгоо зүү арга эх үрсийн чуулганд "Угийн бичиг хөтлөх ач холбогдол" сэдвээр арга зүйн сургалтыг зохион байгуулж 160 гаруй эмэгтэйчүүд хамрагдсан. Мөн хүүхдүүдийн дунд "Ураг удмаа мэдье" ураг удмын багуудын гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 8 баг оролцсон. Хавсралт нийт : 5 Файл : 1 Зураг : 4	70%
37		2.4.10. Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоно.	2021 - 2024	0		Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчигээнд 10 иргэнийг хамруулан мэдээлэл зөвлөгөө өгч мэдээллийн санд оруулсан.	70%
38	2.5. Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ	2.5.1. Сумын нийт ард иргэдийн дунд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна.	2021 - 2024	500000 төгрөг		Малчид төлчдийн зөвлөгөөнөөр төрийн албан хаагч нар болон ардын авьяастнуудын тоглолт үнэ төлбөргүй Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр Ардын авьяастнуудын тоглолт хийгдэж орсон орлого малчдад туслах аянд хандивлагдав Цэргийн баяр Монгол цэргийн өдрөөр сумын бизнес эрхлэгчдийн холбоо малчид ард иргэддээ сэтгэлийн дэм өгөх зорилгоор үнэ төлбөргүй тоглолт Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр дугуйлангийн сурагчдын тоглолт хийлээ. Нийт өөрийн байгууллагын зүгээс хийсэн 4 удаагийн тоглолтод давхард Том хүн 419, хүүхэд 70 Гаднаас ирсэн 2 тоглолт Том хүн 162, хүүхэд 50 Нийтийн цэнгээнт бүжгийг 9 удаагийн бүжиг давхардсан тоогоор 540 иргэн сургуулийн насны хүүхдийн дунд 3 насны ангилаалаар Би дуулах дуртай хүүхдийн дууны уралдаан зохион байгууллаа. Үүнд 26 хүүхэд хамрагдсан. Дууны уралдааныг О.Баасанбат 500000 төгрөгөөр ивээн тэтгэв.	70%
39		2.5.2. Соёлын биет ба биет бус	2021 - 2024	0		Аймаг сумын хамгаалалтад байдаг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	70%

	өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ард иргэдэд сурталчилан таниулна.				үүднээс 14 газрыг ойролцоох нутгалдаг иргэдтэй гэрээ байгуулж ажиллаж байна. Сурталчлан таниулан ажил төлөвлөгөөний дагуу хүлээгдэж байгаа.	
40	2.5.3. Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, хандлагыг өөрчилж “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2024	0		Бүх нийтийн боловсрол олгох арга хэмжээний хүрээнд сургуулийн насны бүх хүүхдүүд, залуу гэр бүлүүдийн дунд Гэр бүлийн үнэ цэнэ нэртэй лекцийг Лектор Бандицэрэнг урьж тавиулсан ЗДТГ азартай хамтран зохион байгуулсан	70%
41	2.5.4. Урлаг соёлын чанар хүртээмжийг дээшлүүлж, үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл сайжруулна.	2021 - 2024	0		2020 онд шинээр ашиглалтад орсон шинэ барилгатай учир үйл ажиллагаа явуулах чанар орчин нөхцөл маш сайн. Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж иргэдэд үйлчилж байна.	90%
42	2.5.5. Иргэдийн ном унших дадал хэвшлийг нэмэгдүүлж, номын сан болон	2021 - 2024	300000		номын сангаар үйлчлүүлэгч 185 хүүхэд 48 том хүнд гэрээр болон танхимаар 1600 гаран ном олгон үйлчиллээ. Номын баяр арга хэмжээг зохион байгуулж шинэ ном болон нутгийн зохиолчдын номоор үзэсгэлэн гаргаж ард иргэд хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн зохион байгууллаа. Номын баярт	70%

		орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сайжруулна.			оролцогчдын дунд АХА тэмцээн 94 хүн, Ном унших сайхан уншлагын аян сарын аянд 185 хүүхэд, "Монгол бичиг" хичээнгүй бичиг, уран бичлэгийн уралдаан зохион байгуулах 6 хүүхэд, Нутгийн зохиолчдын бичсэн номын үзэсгэлэн зохион байгуулахад 94 хүн хамрагдлаа. Орон нутаг судлах танхимыг сургуулийн бага ангийн сурагчдад үзүүлэн хүүхэд багачуудад таниулах ажил хийгдэж байна.	
3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
43	3.1. Газар тариалангийн салбарын үйл ажилагааг дэмжиж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ.	3.1.1. Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцож цаашид төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ	2021 - 2024		Энэ онд эхийн голд 16 өрх, уртын голд 1 өрх, Эрдэнэшанд багт 1 өрх, Зараа 1 дүгээр багт 1 өрх, Эхэнхавцгай 4 дүгээр багт 1 өрх нийт 20 өрх өрхийн тариалалт хийсэн байна. Үүнээс төмс 0.67 га, манжин 0.14 га, хүрэн манжин 0.22 га, лууван 0.48 га, сонгино 0.16 га, өргөст хэмх 0.19 га, улаан лооль 1.2 га, чинжүү 0.14 га, эрдэнэшиш 0.06 га, амтат гуа 0.23 га, газрын алим 0.75 га, бусад хүнсний ногоо 0.2 га, эмийн ургамал лидэр 0.03 га, гүргэм 0.03 га, малын тэжээлийн ургамал арвай 0.5 га, овъёос 1.1 га-д нийт 6.67 га талбайд тариалалт хийсэн байна. Тариалалтын мэдээг өрх тус бүрээр гарган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон сумын статистикийн мэргэжилтэнд өгч нэгдсэн программд шивүүлсэн. Хүүхдийн цэцэрлэг нь уртын голын 1га талбайд 30кг үрийн төмс, 10 кг лууван, 10 кг манжин, 5кг хүрэн манжин зэргийг тариж суулгасан намар хүнсний ногоогоо хураав авч хүүхдийн хоолондоо хэрэглэхээр төлөвлөн ажиллаж байна Хавсралт : 1 файл	70%
44		3.1.2. Нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ	2021 - 2024	20000000	Уртын гол багийн малчин Д.Ганзориг нь Ингэний хоормог, сүү, цагаан идээ үйлдвэрлэх төслөөр 20 сая төгрөгийн зээл авсан. Тус санхүүжилтээр 6 төрлийн уут, хаяг, шошго, 700 литрийн хөлдөөгч, гялгар уутны ам наагч зэрэг сав баглаа боодол, тоног төхөөрөмжийг худалдан авч ингэний хоормог, сүү, ямааны сүү, аарц, говийн болон хэвийн ааруул, хорхой	100%

					болон чипсэн ааруул, шар тос, өрмөн тос, шимийн архи, тараг зэрэг 12 төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж байна. Ингэний хоормогоо сум орон нутагтаа төдийгүй Дархан, Улаанбаатар хот руу захиалгын дагуу нийлүүлдэг. Хавсралт нийт : 8 Файл : 1 Зураг : 7	
45	3.1.3. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг лизингийн болон зээлийн бодлогоор дэмжинэ.	2021 - 2024	149150000		УИХ-ын гишүүн А.Адъяасүрэнгийн дэмжлэгээр уртын голын тариалан эрхлэгчдэд 40-50 морины хүчтэй трактор, эхийн голын тариалан эрхлэгчдэд 80-90 морины хүчтэй иж бүрэн трактор, сумын төвд тариалан эрхлэгч Ш.Бямбасүрэнд 10х12 хүлэмжийг хүлээлгэн өгсөн. Хавсралт : 5 зураг	100%
46	3.1.4. Стандартын шаардлага хангасан хүлэмж, зоорийн тоог нэмэгдүүлэн ашиглалтыг сайжруулна.	2021 - 2024	10000000		УИХ-ын гишүүн А.Адъяасүрэнгийн дэмжлэгээр өгсөн 6х12 хүлэмжийг тариалан эрхлэгч Ш.Бямбасүрэнд хүлээлгэн өгсөн. Хавсралт : 1 зураг	100%
47	3.1.5. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн сумын хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр хангахыг зорьж,	2021 - 2024			Энэ онд эхийн голд 16 өрх, уртын голд 1 өрх, Эрдэнэшанд багт 1 өрх, Зараа 1 дүгээр багт 1 өрх, Эхэнхавцгай 4 дүгээр багт 1 өрх нийт 20 өрх өрхийн тариалалт хийсэн байна. Үүнээс төмс 0.67 га, манжин 0.14 га, хүрэн манжин 0.22 га, лууван 0.48 га, сонгино 0.16 га, өргөст хэмх 0.19 га, улаан лооль 1.2 га, чинжүү 0.14 га, эрдэнэшиш 0.06 га, амтат гуа 0.23 га, газрын алим 0.75 га, бусад хүнсний ногоо 0.2 га, эмийн ургамал лидэр 0.03 га, гүргэм 0.03 га, малын	70%

		Эхийн гол, Уртын гол болон бусад булаг шандыг түшиглэн тариалалтыг нэмэгдүүлнэ.			тэжээлийн ургамал арвай 0.5 га, овьёос 1.1 га-д нийт 6.67 га талбайд тариалалт хийсэн байна. Тариалалтын мэдээг өрх тус бүрээр гарган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон сумын статистикийн мэргэжилтэнд өгч нэгдсэн программд шивүүлсэн. Хавсралт : 1 файл	
48	3.2. Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийг чадавхжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн эрүүл бүс статусаа бататгана.	3.2.1. . Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана.	2021 - 2024		Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сумын хэмжээний 436 үхэр сүрэг хамрагдлаа.Энэ арга хэмжээг 05 сарын 20 -ноос 06 сарын 20 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.	70%
49		3.2.2. Малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулна.	2021 - 2024		хариуцсан албан хаагчид удаа дараа сануулж хэлсэн боловч хэрэгжилтээ ирүүлээгүй	0%
50		3.2.3. Мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлнэ.	2021 - 2024		хариуцсан албан хаагчид удаа дараа сануулж хэлсэн боловч хэрэгжилтээ ирүүлээгүй	0%

51		3.3.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах малын тоог чанарт шилжүүлж “Монгол мал” “Монгол малчин”, “Шинэ хөдөө” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Монгол мал үндэсний хөтөлбөрийн 2 дах шатны зорилтуудыг хэрэгжүүлж, мал сүргийн чанарыг сайжруулах нэгж бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны хаврын үзлэг ангилалтыг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн албатай хамтран Залаажинст -Эдрэн үүлдрийн ямаан сүргийн цөм сүрэг бүхий өрхүүдийн 3000 ямаанд хийв. Мөн энэ үеэр генетик нөөцийн төлөв байдлын судалгааг хийж тодорхойллоо. Монгол малчин хөтөлбөрийн хүрээнд малчдыг нийгмийн даатгалд хамруулах, сургалт суртчилгаанд хамруулах, тэдний хөдөлмөрийг үнэлэх, шагнал урамшилд хамруулах ажлыг зохион байгуулж байна. Шинэ хөдөө хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлж малчдыг хөдөлмөрөө хорших, бүтээмжээ нэмэгдүүлэх зорилгоор Шинэ хоршоо -Чинээлэг малчин малчдын хоршоо байгуулагдаад байна.	70%
52	3.3. Малын чанар ашиг шимийг сайжруулах	3.3.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт болон үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэн, бренд бүтээгдэхүүн бий болгоно.	2021 - 2024	Хоршоог хөгжүүлэх сангаас 20 сая төгрөг	Залаажинст-Эдрэн үүлдрийн ямааны ноолуурыг хоршоогоор дамжуулан угаах, самнах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх арга хэмжээг авч байна. "Цармын цагаан сувд" хоршоо нь ноолуурыг самнан угааж Европын зах зээлд нийлүүлж байна. Ноолуурын экспортын хэмжээ нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Ямаа нэртэй төслийг 2024 оноос эхлэн энэ хоршоогоор дамжуулан хэрэгжүүлж эхлээд байна. "Баянговь цагаан ямаат" хоршоо ноолуураар эцсийн бүтээгдэхүүн хийж гадаад болон дотоодын зах зээлд нийлүүлээд байна. Гадаадын зах зээлд Bodios брендийг гарган нийлүүлж байна. Уртын гол багийн малчин Д.Ганзоригийн Ингэний хоормог, сүү, цагаан идээ үйлдвэрлэх төсөлд Хоршоог хөгжүүлэх сангаас 20 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Тус санхүүжилтээр 6 төрлийн уут, хаяг, шошго, 700 литрийн хөлдөөгч, гялгар уутны ам наагч зэрэг сав баглаа боодол, тоног төхөөрөмжийг худалдан авч ингэний хоормог, сүү, ямааны сүү, аарц, говийн болон хэвийн ааруул, хорхой болон чипсэн ааруул, шар тос, өрмөн тос, шимийн архи, тараг зэрэг 12 төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах	70%

					зээлд борлуулж байна. Ингэний хоормогоо сум орон нутагтаа төдийгүй Дархан, Улаанбаатар хот руу захиалгын дагуу нийлүүлж сард дунджаар 500 литрийг борлуулдаг. Тус хоршоо нь өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлж цех болгох зорилгоор Шинэ хоршоо хөдөлгөөний хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 100 сая төгрөгийн төсөл боловсруулан ХААН банкинд өгч зээл судлагдаж байна. Сумын 70 жилээс өмнө нутгийн брэнд бүтээгдэхүүний багц гаргах чиглэл өгч сум орон нутгийн хэмжээнд дэмжин ажиллаж байна.	
53		3.3.3. Төсөл хөтөлбөрийн хүрээнд малжуулах ажлыг хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Төсөл хөтөлбөрийн хүрээнд малжуулах ажлыг хэрэгжүүлэхээр сумын амжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн 9 малчны материалыг хүргүүлсэн.Хүлээгдэж байгаа.	50%
54	3.4. Үйлдвэржилтийн бодлогын судалгаан дээр үндэслэн сумын үйлдвэржилтийн бодлогыг тодорхойлж зах зээлийг судлах, цаашид эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	3.4.1. Үйлдвэржилтийн бодлоготой уялдуулж орон нутгийн чиглэлийг тодорхойлж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	"Эрдэнэ Монгол" ХХК - 100 сая төгрөг Хоршоог хөгжүүлэх сангаас 30 сая төгрөг	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ард иргэдийн гарааны бизнесийг дэмжих зорилгоор "Эрдэнэ Монгол" ХХК-аас нийт 100000000 (Нэг зуун сая) төгрөгийн санхүүжилттэй "Бичил зээл" хөтөлбөрийг 05 дугаар сараас хэрэгжүүлж эхлэн сумын ЖДҮ эрхлэгчдээс төсөл хүлээн авч 10 төслийг сонгон шалгаруулаад байна. Энэхүү хөтөлбөр нь ХААН банкаар дамжин олгогдох ба 3 жилийн хугацаатай, хүүгүй зээл юм. "Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд 2024 оны 01 дүгээр сард өмнөх оны дутуу санхүүжилт болох 30 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Хоршоо хөгжүүлэх сангаас олголоо. Төслийн үр дүнд 2 дугаар багийн малчин Б.Отгонбаатарыг цалинжуулан цөм сүргийг маллуулж ажлын байр нэмэгдүүлсэн. Шинэ хоршооны хөдөлгөөний хүрээнд 2024 оны 06 сарын 03-нд "Алтат салхит говь" хоршоо нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан "Мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ боловсруулах, худалдах" чиглэлээр төсөл боловсруулан	90%

					бэлтгэн нийлүүлэгч, үйлчлэгч, борлуулагч зэрэг 10 ажлын байр нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна. Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3	
55		3.4.2. Ингэ ямааний сүү хуурайшуулах үйлдвэр байгуулах мөн арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цехийн үйл ажиллагааг сайжруулан байнгын ажиллагаатай болгоно.	2021 - 2024		Аймгийн Ингэний сүү хуурайшуулах үйлдвэрт "Нутгийн хайрханы ивээл" хоршоо нь ингэний сүү нийлүүлэх гэрээ байгуулсан. Арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цехийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байна.	50%
56	3.5. Санхүү эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна	3.5.1. Татварын хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн төсвийн орлогыг татварын нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлнэ.	2021 - 2024	Үйл ажиллагаагаар	Татварын орлогыг оны эхнээс жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллалаа. Сумын Засаг даргын 2023.12.28-ны өдрийн 309,310 тоот албан бичгийг 2 уул уурхайн компанид хүргүүлсний үр дүнд Секэр ресорсус ХХК-ийн туслан гүйцэтгэгч Өрнөх үндэс ХХК татвар төлөгчөөр бүртгүүлэн суутган 1 төрлийн татвараар 37803.0 мян.төг-ийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн. Сумын төсөвт эхний 5 сарын байдлаар 297008.0 мян.төг-ийн орлого төвлөрүүлэхээс 553418.0 мян.төг-ийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлгөөний тэнцлийг 186 хувиар ханган биелүүлсэн. Хавсралт : 1 зураг	100%
57		3.5.2. Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг	2021 - 2024		https://shinejinst.bkh.gov.mn/ сайтад сумын мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг	100%

		хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хэрэглээг иргэдэд сурталчлан таниулж, “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.			байршуулан ажиллаж байна.	
58		3.5.3. Байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, ажилчдыг чадавхижуулан стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2024		Байгаль хамгаалагч, Биеийн тамирын арга зүйч, Багийн ЗД нар, Хууль, эрх зүйн мэргэжилтэн, Оператор албан хаагч нарын ажлын хэрэгцээний төнөг төхөөрөмжөөр ханган ажилласан байна.	90%
59		3.5.4. Төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан хяналт тавина.	2021 - 2024		Эд хөрөнгийн 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийг Тамгын газрын даргын 2024 оны 03 дугаар 12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар ажлын хэсгийн ахлагч Ж.Одонжаргал - Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, нарийн бичгийн дарга Б.Бямбасүрэн – Биеийн тамирын арга зүйч, гишүүд Ц.Шинэзориг - Нярав, Х.Сарантуяа-үйлчлэгч, Ө.Мэнджаргал- Оператор гэсэн бүрэлдэхүүнтэй томилсон. Тооллогыг 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн албан хаагчийн өрөө, няравын агуулах, машин техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг нүдээр үзэж тооллоо. Албан хаагчдын хэрэглэж байгаа эд	100%

					<p>хөрөнгийн ашиглалтын бүртгэл, картыг шинэчлэн бүртгэлээ. Тус карт нь эд хөрөнгийн код, нэр албан хаагчийн нэр он зөрүүтэй байсаныг нэгдсэн бүртгэлтэй тулгаж таарууллаа. Тооллогын ажлын явцад эд хөрөнгийн бүртгэл, код нэг бүрийн үнэ зэргийн үнэ зөв хөтлөж, шинээр авч байгаа эд хөрөнгийг тухай бүрд бүртгэж эзэн холбогдогч дээр бүртгэлжүүлж байх шаардлагатай байна. Тооллого явуулахад хуучны тавилга, эд хөрөнгийг тоолход хүндрэлтэй байлаа. Эд хөрөнгийн код нэр төрлөөр давхацаж байгаа болохоор тоолоход хүндрэлтэй байна. Мөн хүлээж аваагүй эд хөрөнгийг эзэн холбогдогчийн тодруулж дараагийн хүнд шилжүүлэх шаардлагатай байна. Ажлаас гарсан болон шинээр ажилд орж байгаа албан хаагчдын эд хөрөнгийн картыг шилжүүлэн өгч тухай бүр шинэчлэлт хийгээгүйгээс болж зарим нэг эд хөрөнгө шилжүүлж аваагүй гэсэн асуудалууд гарч байна. Тийм учраас тухай бүрд нь албан хаагчдын эд хөрөнгийг бүртгэлжүүлж өгч хариуцлагуулах нь зүйтэй. Багийн Засаг дарга нарын эд хөрөнгийг нүд үзэн тоолж багуудын төв дээр очиж зургаар баталгаажуулсан. Багийн дарга нар болон бусад албан хаагчдын актлах эд хөрөнгийн жагсаалтыг нэг бүрчлэн гаргаж өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлэн ажиллалаа</p>	
60		3.5.5. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхжүүлэн оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.	2021 - 2024		ensur төсөл хэрэгжин ажиллаж байна	50%
4. ДӨРӨВ. Засаглалын бодлого						

61	4.1. Төрийн албаны үйлчилгээг түргэн шуурхай болгож, иргэдийг төрийн нэгдсэн бодлого удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлж, төрийн албанд ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулна.	4.1.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	2021 - 2024			<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу боловсруулан сумын Засаг даргаар батлуулан ажиллалаа. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын талаарх журам өөрчлөгдсөн тул 01 дүгээр сарын 05-ний өдөр 25 албан хаагчдад сургалт, мэдээлэл өгч ажиллалаа. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх Үнэлгээний багийг Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байгууллаа. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд дотоод хяналтын нэгжийг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, холбогдох журмыг баталлаа.</p> <p>Хавсралт : 2 файл</p>	90%
62		4.1.2. Чадварлаг, хариуцлага, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.	2021 - 2024			<p>Албан хаагчдын ёс зүйг сайжруулах хүрээнд “Авлигын эсрэг гэрэл түгээе” уриалга бүхий энгэрийн тэмдэгийг бэлтгэн ажлын байран дээрээ зүүж байна. Мөн Тамгын газрын албан хаагчид аяны хүрээнд Авлигын эсрэг баталгааны маягыг гарган, гарын үсэг зурж хувийн хэрэгтээ хийж ажиллалаа. Төрийн албыг шуурхай ил тод байлгах зорилгоор Засаг даргын Тамгын газраас иргэдээс хамгийн асуугддаг и-монголиа ашиглалтын талаар видео бичлэг хийж, албан ёсны группэд байршууллаа. Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль өөрсдийн үйл ажиллагааны онцлогыг харуулсан шторк хийж байгууллагын албан ёсны фейсбүүк хуудсанд байршуулсан. Мөн нийтийн мэдээлэлд ил тод байхаар заасан 98 төрлийн мэдээг shinejinst.bkh.gov.mn сайтад байршууллаа.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	90%
63		4.1.3. Төрийн	2021 -			Байгууллагын Ил тод байдлыг сайжруулж, сумын сайт дээр	90%

	үйлчилгээний операторын үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэх замаар төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	2024			ил тод байхаар заагдсан 98 төрлийн мэдээг байршуулж байна. Төрийн үйлчилгээний оператор ажлын байрыг баталж, 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Ө.Мэнджаргалыг томилж, цахимын ил тод байдлыг хариуцуулж ажиллаж байна. Мөн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Цахимд хэвшье сургалтад хамруулж, томилолтын зардлыг өгч ажиллаа. Төрийн албаны үйлчилгээг түргэн шуурхай болгож Имонголиа ашиглалтын талаарх заавар зөвлөгөөг Шинэжинст сум Мэдээ мэдээллийн албан ёсны хуудаст байршуулан ажиллалаа. Хавсралт : 1 файл	
64	4.1.4. Мэргэжлийн болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	2021 - 2024			сумын хөгжлийн төлөвлөгөөг мэргэжлийн албан хаагч нар хамтран төслийг хэлэлцэж батлуулан ажил хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.	100%
65	4.1.5. Төрийн байгууллагуудын авто машины парк шинэчлэлтийг	2021 - 2024			ЗДТГ-ын машин эдэрсэн, ЭМТ-ын машиныг ЭМ-ын сайд 7 дугаар сард хүлээлгэн өгөх хүлээлттэй байна. Багийн ЗД нарыг бүрэн мотоциклиор хангасан байна.	50%

		хийнэ.				
66		4.1.6. Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэн бүх нийтийн хандлагыг өөрчилнө.	2021 - 2024		Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудсыг Шинэжинст ЗДТГ, shinejinst shinejinst байгууллагын албан ёсны цахим хуудсуудаар дагаж, өдөр бүр нэвтэрч холбогдох мэдээллийг шэйр хийж олон нийтэд хүргэж ажиллалаа. Гомдол, мэдээлэл хүлээн авах 110 утасны постерыг ашиглан авлигатай тэмцэх газрын албан ёсны фэйж, өргөдөл гомдол хүлээн авах 1111 төв, irgen.bayankhongor.gov.mn сайтыг сурталчлан 04 дүгээр сарын 15-ний өдрийн мэдээллийн цагаар 61 төрийн албан хаагч, 22 иргэнд сургалт орсон. Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчид орсон. Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогчид, санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн зэрэг 12 албан тушаалтны 2023 оны ХАСХОМ-ийн өөрчлөлтийг 2024 оны 02 дугаар сарын 13-ны дотор баталгаажуулж ажиллалаа.ХАСХОМ тайлагналтын талаар Тамгын газрын дарга 2024 оны 01 сард Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогчид, санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн нарт мэдээлэл хийж, ХАСХОМ-ыг бөглүүлсэн.	90%
67		4.1.7. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг үе	2021 - 2024		Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө тусламж өгөх зорилгоор Долоо хоног бүрийн Даваа гарагт иргэдийн “мэдээллийн цаг”-ийг 2024 оны 05 дугаар сарын 13-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Мэдээллийн цагаар албан байгууллагын захирал, дарга, эрхлэгч болон төрийн албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос хамаарч шинэчлэгдсэн болон иргэдэд хэрэгтэй хууль тогтоомж, зөвлөгөө мэдээллийг нийт 11 удаагийн сургалт, 1 АХА тэмцээн (Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын	90%

		шаттайгаар нэмэгдүүлнэ.			тухай хуулийн талаар АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр буюу 05 дугаар сарын 07-нд нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан), 1 гар зургийн уралдаан (Хүүхэд багачуудын татварын тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Татвар хөгжлийн үндэс" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж, нийт 16 хүүхэд бүтээл ирүүлснээс эхний 4 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан) 1 нээлттэй өдөрлөг (эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж зохион байгуулсан ажлын үеэр нэг цэгийн үйлчилгээг ажиллуулж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн) зохион байгуулж ажилласан байна. Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Үндсэн хуулийн талаар нийт 200 ширхэг гарын авлага хийж, байгууллагын дарга нартай биечлэн уулзаж, хууль эрх зүйн чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг танилцуулж, хамтран ажиллах талаар уулзалт хийж 10 ширхэг гарын авлагыг тус тус тарааж өгсөн. 100 ширхэг гарын авлагыг Тээврийн үзлэгийн үеэр иргэдэд тарааж ажилласан.	
68		4.1.8. Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.	2021 - 2024		Төрийн албан хаагчдын ипотекийн зээлийн 3% -д хамрагдах тал дээр сумын Хаан банкттай хамран ажиллах гэрээний дагуу төрийн албан хаагч тухай бүрийн цалингийн тодорхойлолт гарган өгч ажиллаж байна. Ипотекийн зээлд хамрагдсан 4 албан хаагч байна.	90%
69		4.1.9. Сумын Спорт заал, Эрүүл мэндийн төвийн ажилчдын барилгуудад их засвар хийх , ЗДТГазрын	2021 - 2024		ЦЭСДА ХХК-аар	90%

		барилгыг шинээр барих ажлыг хийнэ.					
70		4.1.10. Сумын төв доторх 2 км хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлнэ.	2021 - 2024			хөрөнгө төсөв шийдэгдээгүй байна.	0%
71		4.1.11. Төрийн албаны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхижуулна.	2021 - 2024			Эрдэнэмонгол ХХК-тай хамтран 2024 оны эхний хагас байдлаар эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлээр 20 оюутаныг 2 сарын хугацаанд 1.100.000 төгрөгний цалинтайгаар дадлагажуулан ажиллаж байна. Тухайлбал: Бичгийн хэргийн эрхлэгч, Газрын даамал, Төрийн үйлчилгээний оперотар, архивч	90%
72		4.1.12. Эхийн голыг эрчим хүчээр хангах	2021 - 2024			хөрөнгө санхүү байхгүй.	0%
73	4.2. Архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангаж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулна.	4.2.1. Төрийн байгуулагуудын архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд архивын баримтын нягтруулсан шүүгээтэй болсон байна.	2021 - 2024	Засаг даргын Тамгын газар 2023-2024 онд баримтын хавтас, хайрцаг авахад зориулж 452000 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулав.		Тамгын газар 6, Эрүүл мэндийн төв 2, Ерөнхий боловсролын сургууль 4 баримт хадгалах зориулалтын нягтруулсан шүүгээтэй, байгууллагын архивын баримтыг хадгалах тусгай байртай болж 2000-2023 оны түр болон 70 жил хадгалах баримтыг хадгаламжийн нэгж болгон хавтаслаж хайрцаглан нягтруулсан шүүгээнд хадгалж байна . Хавсралт : 3 зураг	100%

5. Тав: Ногоон хөгжлийн бодлого

74		5.1.1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийнэ.	2021 - 2024	ОНХС 60000000		Тус сумын Зараа 1 дүгээр баг, Уртын гол 2 дугаар баг, Эхэнхавцгай 3 дугаар багуудад уст цэгийн хайгуул хийгдэж, гүн өрмийн худаг гаргуулсан, нийт 60 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэж ажилласан байна.	100%
75	5.1. Байгаль орчныг хамгаалах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ.	5.1.2. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээнэ.	2021 - 2024	17144320		Сумын хэмжээнд элэгдэж эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх, ургамалжуулах газрын судалгааг хийж, хийх ажлын төлөвлөгөөг гарган сумын Тамгын газрын даргаар хянуулан, Засаг даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан. Ургамалжуулах газрын судалгааг гаргаж, хэмжээг тогтоох, шаардлагатай материал, үр, үрсэлгээний тооцоолол хийж, худалдан авах гэрээ байгуулж шаардлагатай материалыг бэлтгэсэн. Хашаа хайс, тор худалдан авахаар Оргил худалдааны төвөөс Эвт дөрвөн жаргал” ХХК-тай 7980700 төгрөгийн гэрээ, суулгац, усны сав, зүлэг цэцэгжүүлэлтэд шаардлагатай материал авахаар “Дэлгэрэх түйн гол” ББН-тай 4932500 төгрөгийн гэрээ, хөрс бордох био ялзмаг, ус нөөцлөх сав болон бороожуулагч авахаар “Домч улаан” ХХК-тай 3015000 төгрөгийн гэрээ, иргэн Ө.Отгонбаатартай шаардлагатай бараа материалыг Баянхонгороос сум хүртэл тээвэрлэх 500 000 төгрөгийн гэрээг тус тус байгуулж ажилласан. Нийт 1 га орчим 6 хэсэг газрыг нөхөн сэргээсэн. Шатахуунд 672000 төгрөг зарцуулсан байна. Хавсралт нийт : 7 Файл : 2 Зураг : 5	100%
76		5.1.3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилан	2021 - 2024	1800000		Аймгийн Засаг дарга Н.Мөнхсайханаар ахлуулсан ажлын хэсэг Шинэжинст суманд ирж ажилласан бөгөөд ард иргэдтэй уулзалт хийж уул уурхайн талаар болон уул уурхай орон нутагт ажиллахад өнөө үеийн нөхцөл байдал, цаг үеийн онцлог, эдийн засгийн хөшүүргийн тухай мэдээлэл,	90%

		таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлнэ.			<p>танилцуулга хийгдсэн. Энэ уулзалт мэдээлэлд 4 багийн нийт 300 гаруй иргэд хамрагдсан. Уг ажлын хэсэг Сэкер ресорсус Монголиа ХХК-ны тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талбайд очиж газар байдалтай нь танилцсан зэрэг ажлууд хийгдсэн. Уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагуудаас Эрдэнэмонгол ХХК, Сэкер ресорсус Монголиа ХХК тус бүр нэг нэг удаа нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж нийт 800 орчим иргэд хамрагдсан. Байгаль орчны хяналтын улсын байцаагч 4 багийн нийт 630 иргэдэд уул уурхайн болон түүнтэй холбоотой хууль эрх зүй, сонирхсон асуултад хариулах байдлаар мэдээлэл хүргэж ажилласан байна. Сургуулийн 1 дүгээр ангийн 2 бүлгийн нийт 66 сурагчдад байгаль орчныг хайрлан хамгаалах чиглэлээр насны онцлогт тохирсон хичээл сургалтыг танхим болон хээрийн аялалаар зохион байгуулсан. Мазаалайн бахархалт өдөр, Дэлхийн усны өдрийн хүрээнд нөлөөллийн ажлууд, сургалт мэдээлэл иргэд, сурагчдад олон талт хэлбэрээр олгох ажлуудад нийт 500 гаруй хүн хамрагдсан, сайн ажил болсон гэж үзэж байна.</p> <p>Хавсралт нийт : 7 Файл : 2 Зураг : 5</p>	
77		5.1.4. “Хоггүй Шинэжинст” аяныг зохион байгуулж хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангана.	2021 - 2024	1300000	<p>Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр холбогдох хууль эрх зүйн баримт, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр батлах тухай” тогтоол батлагдсантай холбогдуулан сумдын хогийн цэгийг шинээр байгуулах чиглэлийн дагуу тус сум нь 2023 онд хог хаягдлын цэгийг дарж булшлах, шинээр байгуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. 2024 онд хог ачигч машин эвдрэл гэмтэл гарсны улмаас өрхийн хог хаягдлыг ачих зөөвөрлөх ажлыг 2 сарын хугацаанд гүйцэтгэж чадаагүйгээс үүдэн хувиараа иргэд хог ачин асгасан нь хогийн цэгт хог бутарсан. Үүнийг ковш трактороор түрэх ажлыг хувийн аж ахуйн нэгжтэй хамтран 2 удаа гүйцэтгэж, хогийн цэгийн ашиглалт сайжирсан үр дүнтэй байна. Хогийн цэгийн хог хаягдлыг</p>	70%

					устгах, түрэх, огшоох ажлыг амжилттай хэрэгжүүлж одоогоор шинээр гаргасан хогийн цэгийн 0,1 хувь орчимд хог хаягдал агуулж байна. Нохой устгал хийгдэж, ариутгал халдваргүйтгэл хийгдсэн. Үүнд 800000 төгрөг зарцуулсан байна. Нийтийн эзэмшил газрын хог хаягдлын ерөнхий байдалд хяналтыг улирал тутамд тавьж ажиллаж байна. Бүх нийтийн их цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж хэвшсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгжийн 120-150 иргэн хамруулж, 1,5-2 тн хог хаягдлыг сар бүр зайлуулж ажиллаж байна. Хавсралт : 1 файл	
78	5.1.5. Зэрлэг амьтдыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдлоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад био техникийн арга хэмжээ авна.	2021 - 2024	3000000		Тус сумын хэмжээнд цас 1 дүгээр сар, 2 дугаар саруудад орсноор зэрлэг ан амьтны өвс тэжээлийн хомсдол үүсч байгаагаас Засаг даргын тамгын газраас биотехникийн арга хэмжээг үе шаттай 4 удаа авч хэрэгжүүллээ. Биотехникийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд тухайн ажил арга хэмжээнд зарцуулах ажлын төлөвлөгөөтэй ажилласан. Байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос 4500000 төгрөг шийдвэрлүүлсэн бөгөөд энэ оны хагас жилд 3000000 төгрөг зарцуулсан. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд Эрдэнэмонгол ХХК, Сэкерресорсус Монголиа ХХК Говийн Их Дархан цаазат газарт мазаалайд хорголжин тавих ажлыг гүйцэтгэсэн байна. Хавсралт нийт : 6 Файл : 1 Зураг : 5	100%
79	5.1.6. 6 Булгийн эхийг хамгаалах ундрагыг сэргээх ажлыг иргэд, малчид, нөхөрлөлийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ.	2021 - 2024	500000		Булгийн эхийг хамгаалах газрын судалгааг Бөөнцагаан орогноурын сав газрын захиргаанд хүргүүлсэн. Эхийн голын нуурын зургалыг Эрдэнэмонгол ХХК засварласан байна. Цагаан булгийн эхийг хамгаалах саналыг иргэд гаргасан бөгөөд малчны бүлгээр хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулагдаад байна. Энэ 6 дугаар сард хийгдэнэ. Хавсралт нийт : 2 Файл : 1 Зураг : 1	70%

80	5.1.7. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хяналтыг сайжруулна.	2021 - 2024	760 000		Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь Байгаль орчинд нөлөөлөх байдалд 25 дэлгүүр аж ахуйн нэгж байгууллагад 1 удаа, 1 тусгай зөвшөөрөл эзэмшигчид 1 удаа, хог хаягдлын ерөнхий байдалд сумын төвийн нийтийн эдэлбэр газарт 3 удаа, иргэний гомдол мэдээллийн дагуу орчны хөрс ургамал бохирдох байдалд 1 удаа, том техник нүүрс олборлосон байж болзошгүй гэсэн мэдээлэлд 1 удаа, заг бутлаг ургамал түүж бэлтгэх байдал, хууль 3 удаа, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн байдалд 2 удаа, хууль бусаар ашигт малтмал олборлолтын байдалд 1 удаа нийт 13 удаагийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж ажилласан байна. Хавсралт : 1 файл	70%
81	5.1.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулна.	2021 - 2024			Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр сумын төвийн ус хангамж, байгууламжийг хайсжуулагдсан, тэмдэгжүүлсэн байгаа бөгөөд хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллаж байна.	70%
82	5.1.9. Орон нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Сумын хэмжээнд аялал жуулчлалын маршрут гаргасан байгаа боловч аялал жуулчлалын бизнес хөгжихгүй байгаа шалтгаан нь цэвэр бохир усны шугам сүлжээнд аж ахуйн нэгж байгууллагууд холбогдоогүй байгаа шалтган нөхцөл байсаар байна. Аялалаар явах иргэдийн тоо өмнөх оноос ихэссэн үзүүлэлттэй байна. Дайран өнгөрөх аялагчид 120 гаруй иргэд зочид буудлаар үйлчлүүлсэн байна. Сумд эвент арга хэмжээ 2 удаа зохион байгуулагдаж гадаадын зочид 12 хүн үзэж сонирхсон байна. Үүнд байгаль орчныг хамгаалах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тэмээний уралдааны үеэр хогийн түр хадгалах цэгийг	70%

					тогтоож, тор байршуулж ажилласан, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг 200 хүнд хүргэж ажилласан.	
83		5.1.10. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг эмх цэгцтэй, бодит байдлаар хийж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Жишиг гудамж” хороолол арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, улс аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж байна.	70%
6. Зургаа: Амар тайван, аюулгүй нийгмийн бодлого						
84	6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах	6.1.1. Сумын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлж хяналтыг сайжруулна.	2021 - 2024		Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаарх сургалтад онлайнаар, согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуй нэгжүүдийг хамруулсан. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчид орсон. Байгууллагын албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх хүрээнд Цагдаагийн хэсгээс Н.Баасанжаргал “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх Тухай” хуулийн талаарх сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулсан.	100%
85		6.1.2. Малчдын бүлгэмийг шинэчлэн	2021 - 2024		Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 4 багийн Иргэдийн нийтийн хурлаар 300-аад малчдад сурталчилж, сан байгуулах тухай хэлэлцүүлэхэд хуралд	100%

		байгуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтран ажиллана.			оролцогчдын 80-аас дээш хувь нь "Манай суманд мал хулгайлах гэмт хэрэг гардаггүй, малчдын хариулга маллагаа сайн" байдаг учраас сан байгуулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Жилийн эцсийн байдлаар мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.	
86		6.1.3. Малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтран ажиллана.	2021 - 2024		Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 4 багийн Иргэдийн нийтийн хурлаар 300-аад малчдад сурталчилж, сан байгуулах тухай хэлэлцүүлэхэд хуралд оролцогчдын 80-аас дээш хувь нь "Манай суманд мал хулгайлах гэмт хэрэг гардаггүй, малчдын хариулга маллагаа сайн" байдаг учраас сан байгуулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Жилийн эцсийн байдлаар мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.	100%
87		6.1.4. Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг соён гэгээрүүлэх үүднээс "Жаргалтай амьдрал төв"-тэй хамтран ажиллана.	2021 - 2024		Архины хамааралтай болсон 4 иргэнийг Аймагт албадан сургалтад хамрууллаа. 2 иргэн 7 хоногийн сургалтад хамрагдаж, 2 иргэн 14 хоногийн сургалтад хамрууллаа. Мөн III улирлаас 2 иргэнийг Жаргалтай амьдрал төвд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	90%
88	6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах	6.1.5. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион	2021 - 2024		Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд сумын хэмжээнд хагас жилийн хугацаанд 4 гол ажлыг зохион байгуулж ажилласан байна. Залуу гэр бүлийн чуулганд 10 гэр бүлийг оролцуулж, мэдээлэл болголоо, гэр бүлийн өдрийн хүрээнд нөхөрсөг волейболын тэмцээн зохион байгуулагдлаа, Чила докторыг урьж ирүүлэн иргэдэд болон сургуулийн сурагчдад лекц уншуулж ухаарал өгөх арга хэмжээг амжилттай зохион байгуулан нийт 800 гаруй иргэд сурагчид хамрагдлаа. Сумын иргэд, албан хаагчдын	100%

		байгуулна.				мэдээллийн цагаар 2 удаагийн сургалт мэдээллийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран зохион байгуулж нийт 300 гаруй иргэд хамрагдсан байна.	
--	--	------------	--	--	--	---	--